

**ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ**  
**“ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШИНЭЧЛЭЛ-II”**  
**ТӨСЛИЙГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ**

Тус эмнэлэг нь Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд хөнгөлөлттэй зээлээр 8 сая еврогийн санхүүжилттэй “Цэргийн төв эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл” төслийг 2020-2023 онд амжилттай хэрэгжүүлж дууссан.

Монгол Улсын Батлан хамгаалах яам болон Австри Улсын “AME интернэйшнл” компаний хооронд байгуулсан “Цэргийн төв эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл-II үе шат” №MoD-СМН-2020-01 дугаартай гэрээний дагуу 61 нэр төрлийн 121 ширхэг нийт 8,000,000 /найман сая/ евро буюу 30,333,280,000 /гучин тэрбум гурван зуун гучин гурван сая хоёр зуун наян мянга/ төгрөгийн дүрс оношилгоо, ангиографи, зүрх судасны эмчилгээний лаборатори, хэт авиан оношилгооны тоног төхөөрөмж, дурангийн оношилгооны тоног төхөөрөмж, ариутгалын тоног төхөөрөмж, вакум хагалгааны өрөө, мэс заслын тоног төхөөрөмж, эрчимт эмчилгээний тоног төхөөрөмж, лабораторийн тоног төхөөрөмж, шүд, эрүү нүүрний тоног төхөөрөмж зэрэг эмнэлгийн тоног төхөөрөмжүүд болон мэс заслын багажуудыг 2022 оны 01 дүгээр сараас эхлэн 2023 оны 08 дугаар сар хүртэл 8 удаагийн тээвэрлэлтээр хүлээн авч, ашиглалтад оруулан, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд бүрэн ашиглаж байна.

№	Тоног төхөөрөмж, багажны иж бүрдлийн ангилал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт үнэ /евро/
<b>Эмнэлгийн тоног төхөөрөмж</b>				
1	Рентген оношилгоо	иж бүрдэл	4	3,632,000
2	Хэт авиан оношилгоо	ш	3	416,400
3	Дуран	ш	3	123,900
4	Ариутгал	ш	6	238,600
5	Мэс засал	иж бүрдэл	51	2,724,700
6	Эрчимт эмчилгээ	ш	22	458,100
7	Лаборатори	иж бүрдэл	5	181,300
8	Шүд, эрүү нүүр	иж бүрдэл	2	91,000
<b>Дүн</b>			<b>96</b>	<b>7,866,000</b>
<b>Мэс заслын багаж</b>				
1	Ерөнхий мэс заслын багаж	иж бүрдэл	19	53,200
2	Шүд, эрүү нүүрний мэс заслын багаж	иж бүрдэл	2	27,600
3	Гэмтэл, бичил мэс заслын багаж	иж бүрдэл	4	53,200
<b>Дүн</b>			<b>25</b>	<b>134,000</b>
<b>Тоног төхөөрөмж, багажны дүн</b>			<b>121</b>	<b>8,000,000.00</b>
<b>Сургалт</b>				
1	Ангиограф /CATH LAB/, электрофизиологийн лабораторийн сургалт	иж	1	-
2	Урологийн тоног төхөөрөмжийн сургалт	иж	1	-
3	Эмнэлгийн менежментийн сургалт	иж	1	-
<b>Дүн</b>			<b>3</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>			<b>121</b>	<b>8,000,000.00</b>

Тус эмнэлэгт шинээр нэвтрүүлсэн оношилгоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмж:



➤ **Ангиографи /CATH LAB/:**

Зүрх судас, мэдрэлийн мэс засал, судасны мэс засалд өргөнөөр ашиглагдах ба зүрхний титэм судасны оношилгоо, эмчилгээ, тархины судасны цүлхэнгийн эмчилгээ, судас залгах, тайрах мэс засалд хэрэглэгдэх бүрэн боломжтой ангиографийн аппаратыг суурилуулсан бөгөөд тус эмнэлэг нь зүрх судасны оношилгоо, эмчилгээг эхлүүлэн 60 гаруй үйлчлүүлэгчид оношилгоо, эмчилгээ хийгээд байна.

➤ **Электрофизиологийн лаборатори:**

Зүрхний хэм алдалтыг эмчлэх тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн иж бүрдэл.



➤ **Вакум хагалгааны өрөө - Ламинар урсгалтай:**

Цэргийн төв эмнэлэгт хагалгааны 7 өрөө ашиглагдаж байгаагаас 5 өрөөг вакум хагалгааны өрөө болгон төхөөрөмжилсөн. Ламинар урсгал бүхий вакум өрөөтэй болсноор эмчлүүлэгчийн хагалгааны дараах халдварын эрсдлийг арилган, эмч, сувилагч нарын ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй нөхцлийг бүрдүүлж, үе солих, эрхтэн шилжүүлэн суулгах хагалгааны өрөөний стандартын шаардлагыг бүрэн хангаж байна.



➤ **Урологийн оношилгоо, эмчилгээний багаж тоног төхөөрөмж:**

- Урологийн дурангийн мэс заслын иж бүрдэл;
- Чулуу бутлагч лазер /дурангийн/;
- Чулуу бутлагч аппарат.

Мэс заслын тусламж, үйлчилгээнд бөөр, давсаг, шээлгүүрийн чулуу авах, түрүү булчирхайн хоргүй хавдар авах, давсагны ургацаг авах, шээлгүүрийн нарийсал засах, бөөрний идээт үрэвслийн эмчилгээ зэрэг урологийн орчин үеийн эмчилгээг шинээр нэвтрүүлэн ажиллаж байна.

➤ **Лабораторийн тоног төхөөрөмж:**

- Бактериологийн анализатор VITEK;
- Цусны ариун чанарын анализатор /BacT/Alert.

Цусны ариун чанар тодорхойлох шинжилгээ болон нянгийн шинжилгээний бүрэн автомат анализаторуудтай болсноор шинжилгээний хугацаа богиносж, оношилгоо, эмчилгээг цаг алдалгүй үзүүлж байна.

➤ Мэс заслын багажны иж бүрдэл:

- Тархи, нуруу нугас, зүрх судас, гэмтэл, бичил мэс заслын багажны иж бүрдэл;

- Шүд, эрүү нүүрний мэс заслын багажны иж бүрдэл.

Цэргийн төв эмнэлэг нь Улсын хэмжээний галт зэвсгийн гэмтэл, Улаанбаатар хотын хүйтэн зэвсгийн гэмтлийг хүлээн авч тусламж, үйлчилгээ үзүүлдэг тул тусгай зориулалтын багажаар хангагдсан нь эмчилгээ, үйлчилгээний давуу талыг олгож байна.

➤ Төвлөрсөн ариутгалын тасаг:

Энэхүү төвлөрсөн ариутгалын тасаг нь хуучин ашиглагдаж байсан ариутгалын хэсгийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлсэн, автоматжуулсан шат дамжлага бүхий, БНХАУ-ын “SHINVA” брендийн тоног төхөөрөмж, табель хэрэгслээр иж бүрэн тоноглогдсон, олон улсын стандартын шаардлагад нийцсэн, ариутгал халдваргүйтгэлийн цогц систем юм.

Үндсэн тоног төхөөрөмжүүд:

- Ус цэвэршүүлэх нэгдсэн систем-1
- Уурын автоклав-2
- Бага температурын плазма ариутгагч-1
- Багаж угааж ариутгах машин-2
- Хатаагч шүүгээ-1
- Шүдний багаж угаагч машин-1
- Багаж угаах даралтат угаалга-1
- Бусад табель хэрэгслүүд /тавиур, тэргэнцэр, бикс, ширээ, уутны ам наагч, материал бэлтгэх ширээ гэх мэт/.



*Сургалт:*

Төслийн хүрээнд дараах нэр төрлийн тоног төхөөрөмжтэй ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд ашиглалтын сургалтыг гадаадын улс оронд зохион байгуулсан.

Үүнд:

- Ангиограф болон электрофизиологийн лабораторийн сургалт;
- Урологийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжийн сургалт;
- Эмнэлгийн менежментийн сургалт.

Сургалт					
1	TRN-01	Ангиограф /CATH LAB/, электрофизиологийн лабораторийн сургалт	иж	1	2023 оны 03 дугаар сард 2 эмч, 2 сувилагч ХБНГУ-д 7 хоногийн хугацаатай сургалтад хамрагдсан.
2	TRN-03	Урологийн тоног төхөөрөмжийн сургалт	иж	1	2022 оны 11 дүгээр сард Бүгд Найрамдах Энэтхэг Улсад 2 эмч, 1 сувилагч, 1 инженер 7 хоногийн хугацаатай суралцсан.
3	TRN-05	Эмнэлгийн менежментийн сургалт	иж	1	БНАУ-д 7 хоног /2023 оны 1 сард/
<b>Сургалтын дүн</b>				<b>3</b>	

*Төслийн үр дүн:*

Төслийг хэрэгжүүлснээр Цэргийн төв эмнэлэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сургалт, судалгааны чансаагаар өндөр хөгжилтэй орнуудын цэргийн эмнэлгийн түвшинд хүрсэн, авархуйн анагаах ухаан, яаралтай тусламжаар үндэсний хэмжээний жишиг эмнэлэг болж, үйлчлүүлэгчид ээлтэй, нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэн, үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл ханамжийг дээдэлсэн, эрүүл мэндийн чанартай, тусламж, үйлчилгээг тасралтгүй сайжруулан хүргэх чадавхийг нэмэгдүүлж, ард иргэдийн гадаад улсад эмчилгээ, оношилгоонд явах урсгалыг багасган, үйлчлүүлэгчдэд цаг алдалгүй төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, амь насыг аврах боломжийг сайжруулж, Улсын төв эмнэлгүүдийн ачааллыг бууруулах зэрэг эдийн засгийн болон Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд оруулах хувь нэмрийг улам бүр нэмэгдүүлэх өндөр ач холбогдолтой байна.